




9-11 нас

ХҮҮХДЭД зориулсан зурган библи

Бүтээлч ном

Хуучин гэрээ
1



Хүүхдэд зориулсан зурган библи

Бүтээлч ном **Хуучин гэрээ 1**

9-11 нас

Эмхэтгэсэн



Орчуулагч | N.Soninbayar График дизайнер | Jeewon Park, Julio Blas Засварласан | N.Soninbayar

Энэ номыг зохиогчын зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлахыг хориглоно.

ГАРЧИГ



1. Бүтээл	6
2. Адам ба Ева	9
3. Каин ба Абел	13
4. Ноагийн хөвөгч авдар	16
5. Бабел цамхаг	19
6. Абрахам	22
7. Содом ба Гоморра	25
8. Исаак ба Ребека	28
9. Иаков 1 (Ах дүү хоёрын зөрчилдөөн).....	31
10. Иаков 2 (Иаков Бетелд)	35

Миний ахиц дэвшил



Тухайн библийн түүхийг үзэж дуусгасны дараа библийг өнгөөр ялган будаарай.



QR кодыг
уншуулан дараах
видеог үзээрэй.



Бүхний эхэнд дэлхий ертөнц харанхуй хоосон, юу ч байхгүй байлаа.

Зөвхөн Эзэн Бурхан л оршиж байв.

Тэгээд нэгэн өдөр, Эзэн Бурхан ингэж айлджээ. “Гэрэл бий болог!”

Бурхан гэрлийг “өдөр” гэж, харин харанхуйг “шөнө” гэж нэрлэв.

Хоёр дахь өдөр нь Бурхан дахин айлдлаа. “Тэнгэр ба ус бий болог”

Түүний хэлснээр тэнгэр ба ус бий болгогджээ.

Гурав дахь өдөр Бурхан газар дээрх усыг нэг дор хуримтлуулан хуурай газрыг ил гаргав.

Тэгээд газар дэлхий дээр нялх ногоо, үрт ургамал, жимсний модыг төрөл төрлөөр нь ургуулаг! гэв.

Дөрөв дэх өдөр Эзэн Бурхан ингэж айлджээ. “Тэнгэрт нар, сар ба одод бий болог!”

Тав дахь өдөр Бурхан айлдсан нь:

“Тэнгэрт дүүлэн нисэх шувууд ба далайд сэлэн амьдрах загаснууд бий болог!”

Зургаа дахь өдөр, Бурхан газар дээр амьдрах амьтдыг бүтээжээ.

Төрөл бүрийн дүр төрхтэй янз бүрийн амьтад бий болж Бурханыг магтацгаав.

Эзэн Бурхан хамгийн сүүлд Өөрийнхөө дүр төрхийн дагуу хүнийг бүтээжээ.

Тэр анхны хүнийг “Адам” гэж нэрлэжээ.

Долоо дахь өдөр болмогц Эзэн Бурхан хийж бүтээсэн бүх ажлаа дуусгаж амрав.

Тиймээс Бурханд итгэдэг хүмүүс долоо дахь өдөр амарцгааж Бурханд

алдар магтаалыг өргөдөг болсон билээ.





Бүтээлч байцгаая 1. Доорх асуултад хариулаарай.

а. Бурхан хэдэн өдрийн дотор дэлхийг бүтээсэн бэ?

б. Бурхан хүнийг бүтээгээд юу гэж тушаасан бэ? Эхлэл 1:28-30

с. Бурхан чамайг бүтээсэнд чи жаргалтай байдаг уу? Яагаад?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Эхлэл 1:1)

Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ.



Бүтээлч байцгаая 2.

Бурханы бүтээсэн зүйлсийг дарааллын дагуу зурж, юу юу бүтээснийг нь бичээрэй.